



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 07 сарын 23 өдөр

Дугаар А/61

Улаанбаатар хот


Баримт бичиг нягтлан шалгах комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйл. 33.5, Архивын ерөнхий газрын даргын 2007 оны 59 дүгээр тушаалаар батлагдсан “Байгууллагын архивын ажлын үндсэн заавар”-ын 2.2.2, 2.2.3 дахь заалт, тус газрын дүрмийн 2.3.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Баримтын үнэ цэнийг нягтлан шалгах, байнгын хадгалалтад баримт шилжүүлэх бэлтгэл ажлыг зохион байгуулах үүрэг бүхий байгууллагын дэргэдэх “Баримт бичиг нягтлан шалгах комисс”-ыг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай. Энэхүү тушаал гарсантай холбоотой 2017 оны А/79 дугаартай тушаалыг хүчингүй болгосугай.

Комиссын дарга:	Орлогч дарга	Ц.Энхтүвшин
Комиссын гишүүд:	Захиргааны хэлтсийн дарга	Д.Ганболд
	Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга	В.Батчимэг
	Мэдээлэл, сурталчилгааны хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч	М.Болортуяа
	Хүний нөөц, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн	С.Баяржаргал
Нарийн бичгийн дарга:	Архив бичиг хэргийн эрхлэгч	Т.Туул

ДАРГА *Д.Батсүх* Д.БАТСҮХ



1159500783